



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 0/412

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн 43 дугаар
цэцэрлэгийн Эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 11,072,739 /арван нэгэн сая далан хоёр мянга долоон зуун гучин есөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Чингэлтэй дүүргийн 43 дугаар цэцэрлэг /Ш.Нямхүү/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн 445,400 /дөрвөн зуун дөчин таван мянга дөрвөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 15 нэр төрлийн 10,627,339 /арван сая зургаан зуун хорин долоон мянга гурван зуун гучин есөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн 43 дугаар цэцэрлэг /Ш.Нямхүү/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050000995

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 07 дугаар сарын 30 өдрийн 0/412 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Чингэлтэй дүүргийн 43 дугаар цэцэрлэг

төгрөгөөр

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
Тавилга эд хогшил										
1	Контейнер	21	ш	1	904,500.00	904,500.00	904,500.00	-	Муудсан	татах
2	Хувцасны шкаф	22	ш	1	279,000.00	279,000.00	279,000.00	-	эвдэрсэн	устгах
3	Ширээ	22	ш	1	166,400.00	166,400.00	166,400.00	-	эвдэрсэн	устгах
4	Дрож	10	ш	1	650,000.00	650,000.00	650,000.00	-	эвдэрсэн	татах
5	Ногоон дрож	9	м	16	45,000.00	720,000.00	720,000.00	-	эвдэрсэн	татах
Тавилга эд хогшлын дүн						2,719,900.00	2,719,900.00			
Тоног төхөөрөмж										
6	Буузны жигнүүр	9	ш	1	550,000.00	550,000.00	550,000.00	-	Шатсан	татах
7	2-р хоолны тогоо	9	ш	1	2,700,000.00	2,700,000.00	2,700,000.00	-	Засварлах боломжгүй	татах
8	Өнгөт принтер	5	ш	1	500,000.00	500,000.00	500,000.00	-	шатсан	татах
9	Зөөврийн компьютер	9	ш	1	1,208,000.00	1,208,000.00	1,208,000.00	-	дэлгэц гэмтсэн	татах
10	Зөөврийн компьютер	5	ш	1	1,150,000.00	1,150,000.00	1,150,000.00	-	дэлгэц гэмтсэн	татах
11	Телевизор	9	ш	1	399,999.00	399,999.00	399,999.00	-	дэлгэц хагарсан	татах
12	Уур сорогч	11	ш	1	180,000.00	180,000.00	180,000.00	-		татах

13	Хөргөгч	14	ш	1	337,440.00	337,440.00	337,440.00	-	мотор шатсан	татах
14	Халаагч	11	ш	2	88,700.00	177,400.00	177,400.00	-	тень шатсан	татах
15	Зурагт		ш	1	450,000.00	450,000.00	450,000.00	-	дэлгэц хагарсан	татах
16	Принтер	5	ш	1	300,000.00	300,000.00	300,000.00	-		татах
17	Суурин компьютер	5	ш	1	400,000.00	400,000.00	400,000.00	-	тэжээлийн блок шатсан	татах
	Тоног төхөөрөмжийн дүн					8,352,839.00	8,352,839.00			
	Нийт хөрөнгийн дүн					11,072,739.00	11,072,739.00			
	Устгах хөрөнгийн дүн			2		445,400.00				
	Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн			15		10,627,339.00				